



Англи хэлний багш Г.Ариунзулын А293 дугаар тушаалын биелэлт

2018-2019 оны хичээлийн жил

Агуулга

1. Төлөвшил.....	3
1.1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал.....	3
1.2. Бусадтай харилцах зан чанар.....	4
1.3. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал, хэвшил, зан чанарын байдал ..	5
1.4. Жижүүр багшийн үнэлгээ	5
2. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц амжилт	5
2.1. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /moodle/	5
3. Авьяасыг нээн хөгжүүлсэн байдал	8
3.1. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх	8
3.2. Олимпиад уралдаан тэмцээн	9
3.3. Бүтээлч ажил	9
3.4. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал	9
4. Боловсролын сэтгэл ханамж.....	9
4.1. Цаг ашиглалт	9
4.2. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн	9
4.3. Багшийн хичээлийн бэлтгэл, сургалтын техник хэрэгсэл ашигласан байдал	10
5. Эрүүл мэнд	10
5.1. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал	10

1. Төлөвшил

1.1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал

2018-2019 оны хичээлийн жилийн II хагас жилийн хугацаанд түүх, нийгмийн ухааны багш Н.Анударь миний бие дараах үйл ажиллагаанд оролцсон байна. Үүнд:

- Нэг баг нэг арга зүй уралдаан тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцож, 3-р байр эзэлсэн. /2018.09.15/
- “Дэлүүн болдогын гэгээн зөн” яруу найргын уралдаанд монгол хэлний секцийнхантай хамтран:
Урилга тараах ажлыг хариуцлагатайгаар хийж дуусгасан.
Зохион байгуулах үйл ажиллагааг амжилттай хийж гүйцэтгэсэн.
- Мэдлэг чадварын сорилд оролцож байгаа сурагчдыг зохион байгуулах, анги танхимийг хуваарилах ажлыг амжилттай гаргаж чадсан.
- “Бүх нийтийн мод тарих өдөр” үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон. /2018.10.13/
- “Дүүргийн Гадаад хэлний багш нарын ур чадварын тэмцээн” - ийг амжилттай зохион байгуулсан. /2018.11.07/
- “Дүүргийн гадаад хэлний багш нарын Илтгэлийн тэмцээн” - ийг амжилттай зохион байгуулсан. /2018.11.20/
- Нийслэлийн бүх анхны жилдээ ажиллаж байгаа багш нарын “Тангараг өргөх ёслол”-д амжилттай оролцсон. /2018.11.02/
- “Авъяаслаг 23” урлагийн наадам – ийг хоёр өдрийн турш амжилттай зохион багуулсан. /2018.11.17-18/
- Мүүдл-ийн сургалтандуудад цаг тухай бүрд нь амжилттай суусан. /2018.12.4/
- Англи хэлний “SPELLING BEE” үсэглэлийн тэмцээнийг амжилттай зохион явуулсан. /2018.12.10-11/
- “Оюуны Элч – 2018” хүндэтгэлийн үйл ажиллагаанд амжилттай оролцсон. /2018.12.14/
- Мөсөн хотхоны үйл ажиллагаанд сэтгэл зүрхээ зориулан амжилттай оролцож, зохион байгуулсан.
- 8 дугаар ангийн англи хэлний мэдлэг чадварын сорилыг Б.Лосолмаа багштай хамтран бэлтгэж, боловсруулах, сурагчдыг үнэлж, мүүдлийн шалгалтыг амжилттай авч дууссан.
- Англи хэлний Б.Лосолмаа – 2 удаа, Б.Алтанцэцэг – 2 удаа , Х.Одончимэг – 3 удаа багш нарын хичээлд сууж, хэлэлцүүлэгт оролцсон.
- Англи хэлний гүнзгий 6в ангийн сурагчдын бүтээл, Стандарт 9-р ангийн сурагчдын бүтээлийг ашиглан самбараа шинэчилдэг. /2018.10-12 сар/
- “Цэнэглэх цаг”ийн хүрээнд “Луужингийн стратеги” сэдэвт лекцэнд хамрагдсан./2018.10.17/
- “Цэнэглэх цаг”-ийн хүрээнд “Эрүүл мэнд гоо сайхан” сэдэвт сургалтанд хамрагдсан./2018.12.03/

- Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд “Эко” сургалтанд хамрагдсан.
- Moodle уралдааны хүрээнд moodle сургалтанд хамрагдсан./2018.1.7-1.11/
- “Авьяслаг 23” урлагийн наадамд зохион байгуулалтаар ажиллаж, туршлага хуримтлуулсан./2018.11.17-11.18/
- Сургуулийн шинэ жилийн арга хэмээний “Яг түүн шиг” хөгжөөнт тэмцээнд Boney M хамтлагийн гоцлол дуучин бүжигчиний дүрийг бүтээж амжилттай оролцсон.
- Цахим номын сангийн нээлт болон танилцуулах үйл ажиллагааны зохион байгуулалтад оролцсон.
- Шанхайн Олон Улсын Хуралд оролцох Сургуулийн танилцуулгыг секцийнхантайгаа хамтарч тус бүр мэдээлэл орчуулсан.
- Шанхайн Олон Улсын Хуралд оролцох Сургуулийн танилцуулгад зориулж Англи хэлний ёс заншил-г илэрхийлсэн цайны ёслол хийх үйл ажиллагаанд амжилттай оролцсон.
- Дүүргийн хэмжээнд гадаад хэлний судлагдахууны багш нарын дунд “Тамирчин багш – 2019” тэмцээнийг амжилттай зохион байгуулж, Шкилжин явах цомыг авсан.
- “Анги удирдсан багш нарын зөвлөгөөн” – д оролцож, багш нарын дунд хэлэлцүүлэг явуулсан.
- “Ангийн дарга нарын зөвлөгөөн” –ийг амжилттай зохион байгуулж, сурагчдын дунд хэлэлцүүлэг удирдан явуулсан.
- “Эцэг эхийн зөвлөгөөн”-ийг амжилттай зохион байгуулж, эцэг эхүүдийн дунд хэлэлцүүлэг явуулсан.
- Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөрлөг үйл ажиллагааны зохион байгуулалтаар ажилласан.
- Гадаад Хэлний баярын үйл ажиллагаанд 6в ангийн 30 сурагчыг хамруулан М.Бүжин багштай хамтарч “CHANTING” бэлдэж, амжилттай оролцсон.
- Гадаад Хэлний баярын үйл ажиллагаанд угтах үйлчилгээ, шагнал гардуулах үйл ажиллагаануудыг амжилттай зохион байгуулсан.
- “Moodle” системийн хэрэгжилтийн үйл ажиллагааг өрнүүлсэн.
- “Moodle” системийн танилцуулга үйл ажиллагаанд оролцож ээлжит хичээл, нэгж хичээлээ мөн мэргэжлийн судлагдахууны тестийн сангуудыг бүрдүүлсэн.

1.2. Бусадтай харилцах зан чанар

Сургуулийн орчинд өөрийн харилцах чадвар, зан чанарт дараах хэвшлүүдийн суулгасан.

Үүнд:

- Багш болон ажилчидтайгаа инээмсэглэж харилцах
- Багш болон ажилчидтайгаа тогтмол мэндэлж байх
- Сурагчидтай нээлттэй харилцах
- Цаг баримтлах
- Төлөвлөгөөтэй байх
- Сайн сонсогч байх
- Цаг тухайд нь ажлаа хийж байх
- Сэтгэлтэй байх

1.3. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал, хэвшил, зан чанарын байдал

Ээлжит хичээлийг бэлтгэхдээ ихэвчлэн цахим хичээл бэлтгэдэг бөгөөд сурагчдад бие даан хийх ажлаар судалгаа, бичлэг, баримтат кинонд дүн шинжилгээ хийлгэх зэрэг үйлүүдийг түлхүү хийлгэж байна. Мөн сурагч бүрийн оролцоог ханган хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд бүрэн хамран оролцуулах идэвхитэй аргуудыг хэрэглэх /дуу, шүлэг, жүжиг, дүрд хувиргах зэрэг/

2. Сурагч бүрийг хичээлийн ном дэвтэр бусад хэрэгсэл бүрэн авчруулах, дасгал ажлын номтой ажиллуулж сургах, өөрийн болон бие биенээ үнэлэх аргад сургах, гэрийн даалгаврын биелэлтийг хянах /дунд ангид гэрийн даалгавар шалгах сурагчид ажиллана// ангид сурагч бүр “би чадна” хөтлөх/

Энэхүү үйл ажиллагааны үр дүнд:

- Сурагчид хичээлдээ илүү идэвхтэй оролцож, бүтээлч байдал нь улам өсөх хандлагатай байна.
- Сурагчдаар уншсан номын тэмдэглэл хөтлүүлсэнээр уран сэтгэмж, унших чадвар, бичих чадварууд нь хурдацтай өсөж байна.
- Бичгийн адварын хувьд англи хэл дээл шүлэг орчуулах, эх уншуулах аргуудыг ашигласнаар сурагчид эсээ бичих арга барилд суралцаж, өөрийн санааа бодлыг сул үг ашиглалгүйгээр шинжлэх ухааны хэлээр ярих бичих хэвшилд суралцах эерэг нөлөө гарсан.
- Хичээл бүр дээр хөгжилтэй, түвшинд нь тохирсон сонсголуудыг сонсгож хэвшүүлсэнээр сонсох чадвар нь ихэд сайжирч байна.
- Хичээлийн болон хичээлийн бус цагаар сурагчдын харилцаанд нэг нэгнийгээ сонсох, хүндэлтэй байх, өөрийгөө чөлөөт цагаар яаж хөгжүүлэх, хувийн менежментийг хэрхэн хийх талаар зөвлөгөө өгч хамтран ярилцдаг.

1.4. Жижүүр багшийн үнэлгээ

II хагас жилийн хугацаанд 2 удаа жижүүр багшийн үүрэг гүйцэтгэсэн. /Хавсралт 1./

- 2019.2.22-ны өдөр жижүүр багш хийж 30 оноо авсан.
- 2019.3.01-ны өдөр жижүүр багш хийж 30 оноо авсан.
- 2019.3.29-ны өдөр жижүүр багш хийж 30 оноо авсан.
- 2019.04.19-ны өдөр жижүүр багш хийж 29 оноо авсан.
- 2019.5.21-ны өдөр жижүүр багш хийж 30 оноо авсан.

2. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц амжилт


2.1. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /moodle/

2018-2019 оны хичээлийн жилийн III улирлын 5, 6, 9 дүгээр ангийн бүлгүүдэд англи хэлний хичээлийн нэгж хөтөлбөрийн боловсруулалтыг хийсэн. Дээрх нэгж хичээлийн хөтөлбөр болон ээлжит хичээлийн нэмэлт мэдээлэл дасгал даалгавар болон тестүүдийг дараах

линкээр орж харах боломжтой. <http://59.153.84.101/moodle/course/index.php?categoryid=1680>,
<http://59.153.84.101/moodle/course/index.php?categoryid=1362>,
<http://59.153.84.101/moodle/course/view.php?id=622>

2.2. Стандарт хэрэгжилт

2018-2019 оны ангиудын гарааны үнэлгээний дүгнэлт График 1



2018-2019 оны I хагас жилийн хичээлийн явцийн үнэлгээ График 2

№	Анги, бүлэг	Дүгнэгдсэн	I	II	III	IV	V	VI	VII	VIII
1	5a	27	0	0	3	1	7	0	9	1
2	5б	29	0	0	3	5	10	1	8	2
3	5г	28	1	1	0	5	4	3	10	4
	5д	31	0	2	0	1	10	2	11	4
	5е	28	0	2	4	2	9	0	10	1
Нийт		143	1	5	7	14	40	6	48	12
3	9в	19	0	0	3	2	6	7	1	0
4	9е	20	1	2	4	5	4	4	0	0
Нийт		39	1	2	7	7	10	11	1	0
Бүгд		182	2	7	14	21	50	17	49	12

- 2018-2019 оны II хагас жилийн хичээлийн явцийн үнэлгээ График 3

Д\д	Анги	С\тоо	I	II	III	IV	V	VI	VII	VIII
Англи хэл										
1	5а	27	0	0	0	0	0	3	15	8
2	5б	28	0	0	0	0	0	8	7	13
3	5г	28	0	0	0	0	1	0	9	18
4	5д	31	0	0	0	0	0	9	12	10
5	5е	29	0	0	0	0	0	8	13	8
6	6б	27	0	0	0	0	2	4	10	10
7	6г	28	0	0	0	0	3	6	11	8
8	9в	19	0	0	0	0	3	3	4	9
9	9е	18	0	0	0	0	4	7	4	3
10										

График 1. 2018-2019 оны ангиудын гарааны үнэлгээний дүгнэлт – ээс харахад 5-р ангийн сурагчид ихэвчлэн VII-VI түвшинг хамарч байна. Харин 9-р ангийн сурагчдын гарааны үнэлгээ VI, V, IV түвшинг хамарсан хангалтгүй үзүүлэлтийг хамарч байна.

График 2.-ээс харахад 5, 9-р ангиудын дийлэнх буюу 67% нь III, IV,V, VI түвшин, 15% нь VII, VIII түвшин тус тус байна. Англи хэлний хичээлээр бие даан дасгал даалгавар хийх, шинэ үгийн мэдлэгээ сайжруулах, ярианы түвшин, бичгийн чадвараа ахиулах шаардлагатай байна гэж үзэж байна.

График 3-аас харахад 6-р анги нэмэгдэж орсон байна. Мэдлэг чадвар эзэмшиж, бүтээлч даалгавар хийж байгаа байдлыг нь харахад илүү сайжирсан үзүүлэлт ажиглагдаж байна.

2.3. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн байдал, бүтээлч ажил

I хагас жилийн хугацаанд хүүхэд бүрийг хичээлийн болон хичээлийн бус цагаар ахиц амжилт гаргахын тулд дараах бие даах ажлуудыг хийлгүүлсэн болно. Үүнд:

- 9 дүгээр анги
 - Улирал тус бүрд 2-3 ном уншиж, тэмдэглэл хөтөлж байгаа.
 - Бүлэг сэдэв бүрээр мэдлэгийг шалгаж өөрсдийгөө сорьж байна.
 - Долоо хоногт нэг удаа сонсгол сайжруулахын тулд дуу, шүлэг уншиж цээжлэн, мөн тестийн сан бүрдүүлэн хамтарч ажиллах аргуудыг хэвшүүлсэн.

- 5 дугаар анги
 - Бүтээлийн сан - хавтас нээж, үзэсгэлэн гаргасан.
 - Шинэ үг цээжлэдэг
 - Дуу шүлэг цээжлэн бие биенээ шалгаж яриа болон сонсголын чадвараа хөгжүүлдэг.
 - Цэвэр бичих чадварыг хөгжүүлж байна.
- 6 дугаар анги
 - Тестийн сан бүрдүүлж долоо хоногт бие биенийхээ хийсэн тестийг баг болон хуваагдаж шалгадаг.
 - Хичээл дээр үзсэн мэдлэгээ ахиулан бататгахын тулд бүтээлч сэтгэлгээг хөгжүүлсэн “Little Book” – бяцхан ном, “Invitation” – урилга хийсэн.

2.4. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал

Сурагчдын сурах үйл ажиллагаанд тулгамдаж буй түгээмэл асуудал нь гэрийн даалгавар дахь дасгал, даалгавар, ээлжит хичээлийн цагаар хийж гүйцэтгэх шаардлагатай дасгал ажил, бие даалтуудтай холбоотой байна. Үүнд багшийн зүгээс дараах арга хэмжээг авсан.

- Ээлжит хичээл бүрийн төгсгөлд сурагчдын дэвтэрт даалгаврыг хэрхэн, яаж хийх тэмдэглэл бичүүлэх, тайлбарлах. Ихэвчлэн 5-р ангийн сурагчдад түлхүү энэ аргыг ашигладаг. Эцэг эхтэй байнгыг харилцаатай байхын тулд.
- Бие даалт, дасгал, даалгаврыг яаж хийх заавар зөвлөгөөг хичээлийн болон хичээлийн бус цагаар зөвлөн тусалсан. Ихэвчлэн 6,9-р ангиудын дунд ашигладаг арга.
- Сурах үйл ажиллагаанд тулгамдаж буй дарамт, стрессийг хэрхэн зохион байгуулах талаар өөрийн туршлагад тулгуурлан сурагчдад зөвлөн тусладаг.

3. Авьяасыг нээн хөгжүүлсэн байдал

3.1. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх

- Англи хэлний хичээл дээр 9е, 9в ангиудын сурагчдын дунд улиралд 2 ном, мөн сурагчдын хүсэлтээр 1 киноны тэмдэглэл хөтлөдөг.

№	Authors Зохиолч	Main characters Гол дүрийн жүжигчид	Plot Агуулга	Settings Зохиолын болсон цаг хугацаа, хаана болсон etc.,
1	...	...	...	...

- Энэ нь сурагчдын унших чадварын дээшлүүлэхээс гадна, бичих чадварт маш их нөлөөлдөг. Мөн сурагчид бичиж байх үедээ бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх чадварт суралцдаг.

3.2. Олимпиад уралдаан тэмцээн

- Англи хэлний гүнзгий 6-р ангийн сурагчдыг ОУ-н Энэтхэгийн олимпиадад оролцуулсан.
- 5, 9-р ангийн сурагчид Олон Улсын Англи хэлний HIPPO олимпиадад сурагчдаа амжилттай оролцуулсан.
- Чингэлтэй дүүргийн англи хэлний олимпиадын 1-н даваанд 9-р ангийн сурагчдыг амжилттай хамруулсан.

3.3. Бүтээлч ажил

- Сар бүр өргөтгөл, шатны самбаруудыг шинэчилдэг.
- Хэлний наадам-н үйл ажиллагаанд зориулан Стандарт 5-р ангийн сурагчид бүтээл хийхэд удирдан чиглүүлсэн.
- “Хэлний наадам-д зориулан 6в ангийн сурагчдыг урлагийн номерт бэлдсэн. “Chanting” – үзүүлбэр.
- Стандарт 6-р ангийн сурагчдаар бие даан Invitation-Урилга, Little book-Бяцхан ном, Story tail-Үлгэр гэх мэт бүтээлч даалгавруудыг хийн гүйцэтгэхэд заавар зөвлөгөө өгч, бүтээлийн сан гаргасан.

3.4. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал

- 5-р ангийн а,б,д,е ангиудын сурагчдад мэдлэгийн түвшинд нь тохирсон шүлэг, дуу цээжлүүлсэн.
- 9-р ангийн в,е ангийн сурагчдад хичээлээс гадуур Англи, Америкийн алдарт Уран зохиолчидтой танилцах, тэдний алдартай зохиолуудыг уншиж, шүлгүүдийг нь цээжлэх гэх мэт сонирхолтой аргуудаар уран сэтгэлгээг нь нээн хөгжүүлсэн.

Боловсролын сэтгэл ханамж

3.5. Цаг ашиглалт

- Хичээлийн болон хичээлийн бус цагаар ээлжит хичээлийн төлөвлөлт, бэлтгэлийг хангаж, сурагчдад зөвлөн туслах, багшлах арга зүйг сайжруулах үүднээс туршлагатай багш нараас зөвлөгөө авч, өөрийн ажилдаа тусган ажилладаг.

II хагас жилийн хугацаанд өөрийн ээлжит хичээлд туршлагатай багш нарыг нийт 5 удаа ажиглалт хийлгэж, багшлах арга зүйн зөвлөгөө авсан. Үр дүнд дараах арга барилд суралцлаа.

- Ээлжит хичээлийг заахдаа багш төвтэй бус сурагчт төвтэй байх
- Самбар төлөвлөлт дээр анхаарах
- Багшлах арга зүйгээ сайжруулж, туршлагатай багш нарын хичээлд сууж, суралцах
- Ээлжит хичээлийн цаг ашиглалтийг нарийн зохион байгуулалттай төлөвлөх шаардлагатай.

3.6. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн

II хагас жилийн хугацаанд сурагчдаас сэтгэл ханамжийн судалгааг санамсаргүй түүврээр нээлттэй асуулгын аргаар судалгааг авсан. Дараах үр дүн гарсан.

- Багшлах арга зүйн хувьд: Цахим хичээл түлхүү ашиглаж, бага зэрэг тод дуугаар ярих зэргийг анхаарах шаардлагатай болох нь харагдсан.

Дунд ангийн сурагчийн ярианаас:

Яг энэ хэвээрээ цахим хичээл орж байвал сонирхолтой байна.

Бага ангийн сурагчийн ярианаас:

Маш гоё хичээлээ заадаг, таны бүх хичээл надад маш сонирхолтой байдаг.

- Сурагчидтайгаа тулгамдаж буй асуудлын талаар байнгийн зөвлөн тусалж, хэрхэн суралцах талаар нээлттэй ярилцаж байх

Сурагчдаас авсан нээлттэй судалгааны үр дүнд дээрх ойлголтуудыг цаашдын багшлах үйл ажиллагаанд тусгах шаардлагатай болох нь харагдлаа.

3.7. Багшийн хичээлийн бэлтгэл, сургалтын техник хэрэгсэл ашигласан байдал

Ээлжит хичээл бүрийн агуулгийг “moodle” цахим системд байршуулсан бөгөөд II хагас жилийн хугацаанд нийт англи хэлний судлагдахууны 48 цахим хичээл бэлтгэж орсон болно. Ээлжит хичээлийн бэлтгэл хангахад дараах хэрэглэгдэхүүнийг хэрэглэдэг.

- Эх сурвалж мэдээлэл
- Хичээлийн үндсэн сурах бичиг
- Цахим эх сурвалж (<http://www.bbc.co.uk/learningenglish/english/features/6-minute-english/ep-13112014>, <https://www.eslbuzz.com/classroom-language-for-english-teachers/>, <https://breakingnewsenglish.com/1710/171011-eating-greens.html>)
- Баримтат кино болон бага хэмжээний бичлэг, видео
- Power point

5. Эрүүл мэнд

5.1. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал

- ✓ Ээлжит хичээлийн цагаар сурагчдад зөв харилцаа, эрүүл харилцааг эрхэмлэх н нэн чухал гэдгийг үйлгуулдаг.
- ✓ Хичээл бүр дээр цэх, зөв суух дадал хэвшлийг сургаж, сурагчдын сурах сэдэл болон биеийн чилээг гаргах үүднээс хичээлийн цагаар гарын дасгал хийдэг.
- ✓ Сургуулийн дасгалын цагаар хичээл орж байгаа сурагчидтай хамтран дасгал хийж хэвшсэн.
- ✓ Ээлжит хичээлийн цагаар эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхийн тулд сурагчдад зөвлөн тусладаг. Тухайлбал хоггүй байх, сандал ширээ цэгцтэй байх, цонх онгойлгож цэвэр агаар оруулах гэх мэт

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЦААШИД АНХААРАХ ЗҮЙЛС

2018-2019 оны хичээлийн жилд нийт 208 сурагчид англи хэлний хичээлийг зааж, 8 түвшингээр үнэллээ. Сургалтын үйл ажиллагааг зохион явуулахад ямар нэг хүндрэл гараагүй, сурагч бүр өөрийн үүрэг хариуцлагаа ухамсарлан хичээлийн үйл ажиллагаанд сайн оролцож байсан. Сурагчид бүтээл хийхдээ маш идэвхтэй биеээ даагаад хийх сонирхолтой байдаг ч зарим сурагчийн хувьд өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд биелүүлдэггүй. Гэсэн хэдий ч сурагчдад сурлагын амжилт, идэвх оролцоогоо сайжруулах боломж олгодог. Бага ангийн сурагчид хичээлдээ маш идэвхтэй, аман шалгалт, шинэ үгийн цээжилсэн байдал зэргийг цаг тухайд нь шалгуулж дараагийн түвшин рүү ахих хандлага их ажииглагдсан.

Бүрэг ичимхий сурагчид өөрийгөө илэрхийлж чаддаг болсон. Мөн гадаад хэлний хичээлээр эзэмших чадваруудыг жигд хөгжүүлэх дунд ангийн сурагчдын хувьд сонсох ярих чадварыг түлхүү хөгжүүлэхийн тулд дуу шүлэг, жүжигчилсэн тоглолт, илтгэх, ном уншин тэмдэглэл хөтлөх харин ахлах ангийн сурагчдын хувьд сонирхолтой сэдвээр илтгэх, хичээл бэлдэн заах зэрэг сонирхолтой аргуудыг хэрэглэн сургалтын үйл ажиллагааг явуулав.

Цаашид төлөвлөсөн төлөвшил чадваруудыг хөгжүүлэх ажлаа нарийн тэмдэглэл хөтлөн сурагч бүрийн ахицыг тооцон ажиллах хэрэгтэй байна. Мөн мэдлэг чадварын сорил шалгалтын дүнгийн анализаас харахад сурагчид хэлзүйн дүрмийн алдаа их байгааг анхаарч одоо болон өнгөрсөн цагуудын ялгааг бүрэн таниулах нь зүйтэй байна. Мөн стандарт хэрэгжилтийн хувьд ангийн сурагчдын түвшнээс доогуур сурч байгаа болон гадаад улсад байсан программын зөрүүтэй сурагчидтай хамтран ажиллаж стандартын хоцрогдолгүй болгоход анхаарч ажиллах болно.